



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.01 № 22
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН
СОНГУУЛИЙН ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Орхон аймгийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн


2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Орхон аймгийн Монгол Ардын намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Намын мөрийн хөтөлбөр ¹³..... хуудсыг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ




Орхон аймгийн Баян-Өндөр сумын Монгол Ардын Намын хорооны 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн...⁴ тоот тогтоолын ...³ хавсралт

АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР /2024-2028/

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Хот хөдөөгийн сэргэлт, 2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарласан бодлогын баримт бичиг, Орхон аймгийн Монгол ардын намын 2024-2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй тус тус уялдуулан сумын 26 багийн түвшинд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор “НИЙГМИЙН АРДЧИЛАЛ-ХҮНИЙ ХӨГЖИЛ” уриан дор боловсруулсан мөрийн хөтөлбөрөө танилцуулж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1 Боловсрол
- 1.2 Үндэсний соёл, өв уламжлал
- 1.3 Эрүүл мэнд
- 1.4 Спорт, Соён гэгээрэл
- 1.5 Нийгмийн баталгаа



ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1 Эдийн засгийн хөгжил
- 2.2 Дэд бүтэц
- 2.3 Эрүүл хүнс,
- 2.4 цэвэр орчин
- 2.5 Аялал жуулчлал
- 2.6 Ногоон хөгжил

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН БОДЛОГО

- 3.1 Засаглал
- 3.2 Цахим хөгжил



НЭГДҮГЭЭР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. БОЛОВСРОЛ

- 1.1.1. Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй байлгаж, хүүхдийг дарамт хүчирхийлэлээс ангид байх таатай орчныг бүрдүүлэн иргэдийг насан туршийн боловсролын төвд хамруулан тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүтээмжийг дээшлүүлж боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, менежментийг сайжруулна.
- 1.1.3. Хүн амын өсөлт, нягтралд үндэслэн ЕБС, цэцэрлэгийг тоог нэмэгдүүлж, анги дүүргэлтийг стандартад нийцүүлнэ.
- 1.1.4. Ерөнхий боловсролын сургуулиудад хиймэл оюун ухаанд суурилсан кабинет байгуулахыг, дэмжиж хамтран ажиллана.
- 1.1.5. Боловсролын хөгжлийн асуудлаар бүс нутаг, үндэсний түвшний арга хэмжээ, уламжлал шинэчлэлд суурилсан форум уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна.
- 1.1.6. Их дээд сургуулиудын эрдэмтдийн зөвлөлтэй хамтарч судалгаа, шинжилгээнд суурилсан мэдлэг мэдээллийг боловсруулж, боловсролын чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 1.1.7. Бүх шатны боловсролын байгуулагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, биеийн тамирын заал танхимаар хангаж, суралцагчдад сурч хөгжих ээлтэй орныг бүрдүүлнэ.
- 1.1.8. Цэцэрлэг, сургуулийн бага дунд боловсролын агуулга стандарт чанарыг дээшлүүлж, эрсдэлт бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулан хүүхдийг суралцахууд суурилсан амьдралын зөв дадалтай болгоно.
- 1.1.9. Их дээд сургуулиудын шинэ мэдлэг бүтээх технологи үйлдвэрлэх, инноваци гаргаж, хэрэглээнд нэвтрүүлэх, эко системийг бий болгох санал санаачлагыг дэмжиж хамтарч ажиллана.
- 1.1.10. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркыг түшиглэн боловсрол-эрдэм- шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог хөгжүүлж, оюутны сургалтын чанарыг дээшлүүлж, бүтээлч байдлыг төлөвшүүлнэ.
- 1.1.11. Цэцэрлэг, сургуулийн орчны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж, авто замын гарц, тэмдэг тэмлэглэгээг цогцоор нь бүрдүүлж, сумын хэмжээнд "school zone" аяныг өрнүүлж, хүүхдийн аюулгүй, эрсдэлгүй таатай орчинд суралцах боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.12. Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоол, сурагчдын дотуур байрны хоолны стандартад хяналт тавьж, орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.13. ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чадамжид суурилсан "Мэргэжил сонголт ба зорилготой сурагч" хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.



- 1.1.14. “Монгол хүн” бэлтгэх үндэсний өв соёл, уламжлал, зан заншил, амьдрах ухааны агуулга бүхий боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа төр, хувийн хэвшлийн сургуулиудыг дэмжинэ.
- 1.1.15. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, политехникийн коллеж, мэргэжил олгох сургалтын төвд суралцагчдыг хойд бүсийн хэмжээнд эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр сургах, мэргэжлийн чиг баримжаа бүхий ажилтанг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.1.16. Үндэсний өв соёл, уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр мэргэжил олгож буй сургалтын байгууллагыг бодлогоор дэмжинэ.
- 1.1.17. Хүүхэд, залуучуудын хөгжлийн цогцолбор төв, олон улсын чанар, стандартад нийцсэн жишиг ерөнхий боловсролын сургууль, номын төвийн үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

1.2.ҮНДЭСНИЙ СОЁЛ, ӨВ УЛАМЖЛАЛ

- 1.2.1. Өв соёлыг хадгалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, монгол үндэсний соёлын онцлогийг агуулсан орон нутгийн бүтээлүүд, шинэлэг уран бүтээлийн төсөл, санал, санаачилгыг дэмжиж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийг тогтвортой байлгах бодлогыг баримтална.
- 1.2.2. Ардын уламжлалт зан үйл, ёс зүй, зан заншил, зөв амьдрах ухаан, хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд монголчуудын оруулсан хувь нэмэр, байгальтайгаа хүйн холбоотой амьдарч ирсэн Монголчуудын өв уламжлал, харилцааны ёс зүй, суурь үнэт зүйлсийг цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт оруулж хэрэгжүүлнэ.
- 1.2.3. Үндэсний өв соёлыг орон нутагт олон талт агууллагаар баяжуулж, сурталчилан таниулах замаар монгол орны соёлын орон зайн үнэт зүйлийг өсгөнө.
- 1.2.4. Төр иргэний хамтын ажиллагааны түншлэлд үндэслэн соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварыг хамгаалан, хөгжүүлж, эдийн засаг нийгмийн үр өгөөжийг дэмжиж ажиллана.

1.3.ЭРҮҮЛ МЭНД

- 1.3.1. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн менежментийг сайжруулж, тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн чадавхийг сайжруулна.
- 1.3.2. Нийгмийн эрүүл мэндийн төвийг орон нутагт байгуулж хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх, сургалт, мэдээлэл арга зүйгээр хангах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.3. Нийгмийн болон орчны эрүүл мэндийн тандалт судалгаа хийж үр дүнд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөлөх эм бодисын хэрэглээнд хяналт тавьж, сургалт мэдээллийг тогтмол зохион байгуулж, эрүүл, амьдралын зөв дадал, хэвшлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

- 1.3.5. Иргэдийн дунд зохион байгуулж буй урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгүүдийг хийхэд дэмжлэг үзүүлж, оролцоог нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.6. Өрхийн эрүүл мэндийн төвүүд иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.
- 1.3.7. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шүдний эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр дэмжиж, боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулна.
- 1.3.8. Нийгмийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний мэргэжилтнүүд болон багуудын нийгмийн ажилтны хамтын ажиллагааг сайжруулж, бодлого арга зүйгээр ханган ажиллана.
- 1.3.9. Нийгмийн эрүүл мэндийн төвийн дэргэдэх судалгаа шинжилгээний лабораторийг тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.10. Эрүүл амьдралын дадал хэвшилтэй холбоотой иргэдэд чиглэсэн соён гэгээрлийн ажлыг тогтмол зохион байгуулж, эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн, эрүүл хооллолт, эрүүл амьдралын эрүүл хэв маягт суралцах сургалт мэдээллээр хангаж ажиллана.
- 1.3.11. Эрүүл мэндийн газартай хамтран сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжлийн мэдлэг арга зүйгээр хангах, ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн насны хүүхдүүдэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгоход дэмжлэг үзүүлнэ. /электрон тамхины хэрэглээ, дэлгэцийн хамаарлаас ангид байлгах/
- 1.3.12. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн эмнэлгийн уялдаа холбоог сайжруулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд татан оролцуулна.
- 1.3.13. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг сайжруулах, үйлчилгээний байгууллагын харилцаа хандлагыг шинэ түвшинд гаргаж, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.
- 1.3.14. Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд чиглэсэн “Эрүүл иргэн-Эрүүл хамт олон” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.15. Анхан болон лавлагаа шатлалын оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэд технологи нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.4. СПОРТ, СОЁН ГЭГЭЭРЭЛ

- 1.4.1. Биеийн тамирын байгууллагуудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, менежментийг сайжруулж, нийтийн биеийн тамирыг эрчимтэй хөгжүүлнэ.
- 1.4.2. Бүсийн хэмжээний спортын тэмцээнийг өвөл, зуны тодорхой төрлөөр зохион байгуулах боломжийг бүрдүүлж спортын арга хэмжээг зохион байгуулна.
- 1.4.3. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг олон төрөлт спортоор хичээллэх боломжийг бүрдүүлж, биеийн тамирын заал барих ажлыг төр хувийн хэвшлийн хүрээнд хамтран зохион байгуулна.
- 1.4.4. Орон нутгийн иргэдийн ая тухтай эрүүл аюулгүй амьдрах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр эрүүл мэндийн

чийрэгжүүлэлтийн талбайг нэмэгдүүлж эрүүл амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

- 1.4.5. Улс болон олон улсын түвшинд амжилт гаргаж буй спортын баг тамирчдыг бодлогоор дэмжинэ.
- 1.4.6. Иргэдийг соён гэгээрүүлэх үүднээс спортын төрлүүдийг сурталчилах, таниулах үүднээс хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч нэвтрүүлэг сошиал контент үйлдвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 1.4.7. Сумын доторх тодорхой чиглэлд дугуйн замуудыг шинээр нэмэгдүүлж, түр амрах цэгүүдийг байгуулж, орон сууцны байруудад дугуйн зогсоолыг хийх аян өрнүүлэн хэрэглээг нэмэгдүүлнэ.

1.5. НИЙГМИЙН БАТАЛГАА

- 1.5.1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд орон нутагт хязгаарлагч хүчин зүйлсийг арилган эдийн засгийг тэлсэнээр нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.
- 1.5.2. “Халамжаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлэн зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлж, ур чадварыг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрт хамруулна.
- 1.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.4. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан зэрэг зорилтод бүлэг рүү чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын бодлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах ажлыг нийтэд нээлттэй зохион байгуулна.
- 1.5.5. Хүүхэд хамгаалалын талаар мэдлэг ойлголт хандлагыг нэмэгдүүлж, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.
- 1.5.6. Ахмадын хөгжлийн төвийн үйлчилгээний стандартыг бий болгож, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.5.7. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцлийг бүрдүүлж буй төр, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 1.5.8. Хөдөлмөрийн хуулинд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх бодлого баримтлана.
- 1.5.9. Тогтвортой гэр бүлийг дэмжих зорилгоор гэр бүл салалт, хүчирхийлэлийн эрсдлийг бууруулах чиглэлээр сэтгэл зүйн мэргэжлийн байгууллагуудтай хамтран соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.5.10. Цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийг уртасгаж, эцэг эхчүүдийн ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.11. Зайнаас болон цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийн уян хатан зохицуулалтыг бий болгож иргэдийн нэмэлт орлого олох боломжийг олгоно.

- 1.5.12. Баялагийн сан, нийгмийн даатгалын сангаар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулах, иргэдэд түрээслэх болон түрээслээд өмчлөх орон сууцны төслийн ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.5.13. “Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН БОДЛОГО

.1. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

- 2.1.1. Хотын нөөцийн давуу талд тулгуурлан уул уурхай-металлурги-хими, катодын зэс боловсруулах үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.1.2. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, ажлын байрны тоог нэмэгдүүлэн өрхийн бодит орлогыг өсгөнө.
- 2.1.3. “Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркийн дэргэдэх бизнес инкубацийн үр ашгийг сайжруулж, бойжигчдын тоог нэмэгдүүлж жижиг дунд бизнес эрхлэгчдийн хүрээг өргөжүүлнэ .
- 2.1.4. Өндөр технологид тулгуурласан экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх боломжийн судалгааг өргөжүүлж инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.1.5. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах ажилд орон нутгийн аж ахуй нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжиж хамтран ажиллана.
- 2.1.6. Нөөцийн махыг орон нутгийн иргэд, аж ахуй нэгж, байгууллагад түшиглэж бэлтгэнэ.
- 2.1.7. “Эрдэнэт” ТӨҮГ болон бусад томоохон үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлж хорших, туслан гүйцэтгэх үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.1.8. Хоршооллыг дэмжих сангийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулж, орон нутгийн хоршоологчдыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- 2.1.9. Хойд бүсийг түшиглэн Баян-Өндөр сумыг эко хүнсний бүтээгдэхүүнээр хангах аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 2.1.10. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шинэ механизмыг бодлогоор дэмжиж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.11. Хил залгаа бүс нутаг, орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлох үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд технологийг нэвтрүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах бодлого барина.
- 2.1.12. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагуудын чанар стандартад хяналт тавьж, бизнес үйл ажиллагааг дэмжих, цар хүрээг өргөжүүлэх ажлыг бодлогоор дэмжиж төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.1.13. Барилга, барилгын материалын чиглэлийн шинэ үйлдвэр, үйлчилгээг дэмжихийн хамт Хойд бүсийн хэмжээнд бизнес клубуудыг байгуулах ажлыг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.



- 2.1.14. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэдийн хяналтын бүлэг байгуулан хяналт тавьж ажиллана.
- 2.1.15. Төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбийг үр өгөөж, нийгмийг үр ашигт тулгуурлан эрэмбэлж, дарааллыг тогтооно.
- 2.1.16. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, шинэ аж ахуйн нэгжүүд зах зээлд нэвтрэх бэрхшээлийг бууруулна.
- 2.1.17. Орон нутгийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний хангамж, хадгалалт, эрүүл аюулгүй байдлыг хангах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.1.18. Дөрвөн улирлын аялал жуулчлал ба соёлын бүтээлч үйлдвэрлэл. Булган, Хөвсгөл аймгуудруу аялах иргэдийн дамжин өнгөрөх, амрах, буудаллах нөхцөлийг бүрдүүлж, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээг өргөжүүлэх, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэх /зочлох үйлчилгээний салбарыг хөгжүүлэх/ ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.19. Нэрийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түүнийг бий болгож буй үйлдвэрлэгч, өрхийн болон ЖДҮ-ийг дэмжинэ.
- 2.1.20. Нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэр. Боловсруулах аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах урт хугацааны стратегийн хүрээнд ДНБ-д эзлэх боловсруулах үйлдвэрийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ. Үүний дотор хүнс, хөнгөн үйлдвэрүүдээс орох орлогыг нэмэгдүүлэх бодлогыг эрчимтэй дэмжинэ.
- 2.1.21. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх замаар хуримтлалыг бий болгох, хөрөнгийн зах зээлийг мэдлэгийг нэмэгдүүлж түүнээс олох орлогыг өсгөнө.
- 2.1.22. Хоршоололд суурилсан эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, малчдын орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын боломжуудыг бий болгож, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.
- 2.1.23. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах, борлуулах нэгдсэн тогтолцоог хувийн хэвшилтэй хамтран шинэчлэн бий болгож, салбараас олох орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.1.24. Өрхийн тариалалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүлэмж төслийг хэрэгжүүлж ажиллана.

2.2. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

- 2.2.1. Шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудын барилгажилтад иргэдийн хяналтын бүлэг байгуулан хяналт тавьж, иргэдэд тэгш хүртээмжийн боломжийг олгох нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 2.2.2. Дахин төлөвлөлтийн хүрээнд шинээр орон сууцжуулах бодлого боловсруулж, төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгож, бодлогоор дэмжин ажиллана.
- 2.2.3. Шинээр хашаа байшин, сууц барьж буй иргэдийг ипотекийн зээлд хамруулна.
- 2.2.4. Зэргэлдээх сумдуудтай хамтын ажиллагааны хүрээнд шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг хамтарч зохион байгуулна.
- 2.2.5. Орон нутгийн инженерийн шугам сүлжээг тодорхой үе шаттай шинэчлэн сайжруулна.



- 2.2.6. Баян-Өндөр сумын гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандартыг хэрэгжүүлнэ.
- 2.2.7. Дулааны цахилгаан станцын шинэчлэлд суурилж гэр хорооллын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.2.8. Гэр хорооллын багуудад “Жишиг гудамж” төслийг хэрэгжүүлж зам талбай, гэрэлтүүлэг, камержуулалтыг дэс дараатайгаар үргэлжлүүлэн шийдвэрлэнэ.
- 2.2.9. Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ.
- 2.2.10. Гэр хорооллын алслагдсан багуудад цахилгаан эрчим хүч түгээх, хүчдлийн уналтыг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж ажиллана.
- 2.2.11. Орон сууцны хорооллуудын дунд авто машины зогсоол барих иргэд аж ахуй нэгж, байгууллагуудын санал санаачлагыг дэмжиж ажиллана.
- 2.2.12. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл маршрутыг иргэдийн саналд тулгуурлан оновчтой болгож, нийтийн тээврийн үйлчилгээний стандарт боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.2.13. Авто замын эвдрэлд үнэлгээ тогтмол хийж, урьдчилсан засвар, арчилгаатай авто замын сүлжээ бүхий сум болно.
- 2.2.14. Нийтийн орон сууцны хуучин барилгын дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 2.2.15. Иргэдийн амрах ногоон байгууламж бүхий талбайн тоог нэмэгдүүлж, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад, жирэмсэн эхчүүдэд ээлтэй байхаар зохион байгуулна.
- 2.2.16. Гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэл гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай шинэчилнэ.
- 2.2.17. Камерын хэмжилтийн мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулах, хотын хөдөлгөөн, бохирдол, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй авч дүн шинжилгээ хийдэг, зохицуулах арга хэмжээ авдаг системийг бүрдүүлнэ.
- 2.2.18. Хиймэл оюун ухаанд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зарлан мэдээлэх, дуут дохио ажиллуулах менежментийг боловсронгуй болгоно.
- 2.2.19. Тээврийн хэрэгслийн насжилт, түүнээс гарах бохирдолд тавих стандартыг сайжруулж мөрдүүлэх, нийтийн тээвэр, явган зорчигчдод ээлтэй дэд бүтцийг хөгжүүлж, автомашинаас гарах агаарын бохирдлыг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулна.
- 2.2.20. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, иргэдийн хашааг орон сууцаар солих эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллана.
- 2.2.21. Алслагдсан багуудын дэд бүтэц, төрийн нэгдсэн үйлчилгээ авах байр, ахуйн үйлчилгээг хүртээмжтэй болгож амьдрах нөхцөлийг сайжруулна.
- 2.2.22. Ногоон зээлийн санхүүжилтээр олон улсын байгууллагатай хамтран нарны панел, цахилгаан хураагуур, халаалтын системийг нэвтрүүлэх, байшин-гэр хорооллын дулаалга, дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.
- 2.2.23. Алслагдсан багуудад нийтийн тээврийн маршрутыг шинэчлэн гаргаж, автобусны буудлыг өвлийн улиралд нийцүүлэн тохижуулж, иргэдийн тав тухтай байдлыг хангана.

- 2.2.24. Нийтийн тээвэр, дуудлагын такси үйлчилгээ, зогсоолын такси үйлчилгээг нэгтгэсэн платформыг үүсгэж, иргэдэд түргэн шуурхай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.2.25. Цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай өргөтгөлүүдийг хийнэ.
- 2.2.26. Хүлэмжийн хийг бууруулах стратегийг утаа, эрчим хүч, өрхийн халаалтын шийдэлд зэрэг тулгамдсан асуудалд чиглүүлж, олон улсын байгууллагаас санхүүжилт татаж, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.2.27. Гадаргын ус, газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.
- 2.2.28. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглан, усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.

2.3. ЭРҮҮЛ ХҮНС

- 2.3.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг байгуулж орон нутгийн түвшинд иргэдийг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.3.2. Орчин үеийн шийдэл бүхий хөргүүртэй хүнсний худалдааны төв байгуулж, иргэдийн хүнсний ногооны хэрэгцээг ханган ажиллана.
- 2.3.3. Хүн амын хэрэглээний усыг ангилан саарал усыг ашиглах, ундны усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх технологийг нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлнэ.
- 2.3.4. Гадаргын усны ашиглалтыг сайжруулж, усны эх булаг, шандыг хамгаалан тохижуулж, усны нөөцийн хамгаалалт, хэмнэлттэй технологийг нэвтрүүлж, гүний худаг байгуулах ашиглахыг хязгаарлан, бохирдолтыг бууруулах ажлыг эрчимжүүлнэ.
- 2.3.5. Усны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хот, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, усны нөөц бохирдож, хомсдохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.3.6. Хүн амын ус хангамжийн системийн эх үүсвэрийн аюулгүй байдалд хяналт тавьж, нөөцийг тогтоох, газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлж, чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөнө.
- 2.3.7. Баян-Өндөр сумын болон хил залгаа сумдын нутаг дэвсгэрт өрхийн тариалалтыг дэмжих, хамтарч ажиллах төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.3.8. Үүлдэр омог гойд ашиг шимт малыг өсгөн үржүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажлыг өргөжүүлж шинэ хоршоолол, фермерүүдийн үйл ажиллагааг дэмжиж, мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний стандартад нийцсэн материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.
- 2.3.9. Баталгаатай, стандартад тохирсон хүнс, ногоо, мах махан бүтээгдэхүүнээр найдвартай хангадаг үйлчилгээний цэг, салбар төвүүдийг бодлогоор дэмжинэ.
- 2.3.10. Өндөр ургац өгдөг сортын жимс жимсгэний тариалалтыг өрхийн хэмжээнд нэмэгдүүлнэ.
- 2.3.11. Хүлэмжийн аж ахуй байгуулах, нарийн ногоо тарих хөдөлгөөн өрнүүлж, дөрвөн улирлын хүлэмж байгуулах иргэд, аж ахуй нэгж, байгууллагын санал санаачлагыг дэмжин хамтран ажиллана.

ЦЭВЭР ОРЧИН

- 2.4.1. Хөрсний бохирдолыг бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг дэмжиж урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгон төр, хувийн хэвшлийн бүх байгууллагад ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ.
- 2.4.2. Ногоон айл өрх, байгууллага, гудамж, хороолол бий болгох бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж ногоон орчинг бий болгоно.
- 2.4.3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр дахин боловсруулах үйлдвэр байгуулж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа, санал санаачлагыг бодлогоор дэмжин хамтран ажиллана.
- 2.4.4. Голын гольдрол, гуу жалга, далангийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үерийн далангийн байгууламжийг нэмэгдүүлэн гадаргын усны бохирдлыг бууруулна.
- 2.4.5. Баян-Өндөр, Сархиа уулыг ойжуулах, тохижуулах арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 2.4.6. Ойн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх, ойн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалахад ой модны зохистой ашиглалт, тогтвортой менежментийг бий болгож, ойн санг нэмэгдүүлэн, модны хэрэглээг бууруулна.
- 2.4.7. Алхах, дугуй унахад аюулгүй тав тухтай байдлыг ханган хотын хөдөлгөөн хязгаарлаж буй хашаа, хаалтуудыг үргэлжлүүлэн буулгаж, зорчих хэсгийг сайжруулна.

2.5. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 2.5.1. Сумын аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийг нэг дороос авч болох "erdenet app"-ыг бий болгож үйл ажиллагааг нь тогтмол болгон, гадаад дотоодын жуулчдыг татах бэлтгэх ажлыг хангана.
- 2.5.2. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдлыг сайжруулан өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, иргэдийн аялал жуулчлалын бизнесийн мэдлэгийг дээшлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.5.3. Аялал жуулчлалын чиглэлээр бүсийн хэмжээнд форум, уулзалт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлж, сургалт, сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлнэ.
- 2.5.4. Орон нутагт зорин ирж буй болон дайран өнгөрч буй жуулчдын судалгааг жуулчны үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан нарийвчлан гаргадаг механизмыг бүрдүүлэх, хотын аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгоно.
- 2.5.5. Орон нутгийн онцлогийг харуулсан гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих орон нутгийн иргэд аялал жуулчлалын салбараас орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.5.6. Өвлийн спортын материаллаг баазыг бэхжүүлж, өвлийн саруудад зохион байгуулах арга хэмжээний тоог нэмэгдүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.



- 2.5.7. Нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.5.8. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.
- 2.5.9. Аялал жуулчлалын дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.5.10. Аялал жуулчлалын агентлаг, аялалын операторын чиглэлээр хүний нөөц бэлтгэнэ.
- 2.5.11. Нүүдэлчин соёл иргэншлийг харуулсан үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, үндэстэн ястны эвент арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, бодлого үйл ажиллагаагаар дэмжин ажиллана.
- 2.5.12. Орон нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, орон зайн төлөвлөлт хийнэ.

2.6

НОГООН ХӨГЖИЛ

- 2.6.1 Байгаль орчны нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, уул уурхай чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын нөхөн сэргээлтийг хийлгэж орчны бохирдлыг бууруулна.
- 2.6.2 Иргэдийн оролцоонд тулгуурласан хотын хөгжлийн төлөвлөгөөг цахим технологи нэвтрүүлэн, иргэн бүрийн саналыг тусгаж, төр, хувийн хэвшил, иргэдийн шинэлэг санаа, олон улсын туршлага, инновацад түшиглэсэн шийдлийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоно.
- 2.6.3 Сумын хэмжээнд агаар хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг арилгах ажлыг бүх түвшинд нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг хийнэ.
- 2.6.4 Гэр хорооллын өрхүүдэд эдийн засгийн ач холбогдол бүхий жимсний мод бут сөөгийг тариалах ажлыг төрөөс дэмжиж, өрхийн хүнсний хэрэглээ болон орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.6.5 Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.6.6 Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, ойн сангийн талбайг нэмэгдүүлнэ.
- 2.6.7 Цахим бүртгэлийн систем байгуулж, таримал мод, ногоон байгууламжийг бүртгэлжүүлнэ.
- 2.6.8 Мод, бут, сөөг тарьсан ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах, бүртгэлийг цахимжуулна.
- 2.6.9 "Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоотой уялдуулна.



- 2.6.10 Мод үржүүлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллага, ойн нөхөрлөлүүдтэй хамтран хот доторх ногоон төгөл байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.6.11 Зэргэлдээх сумдуудтай хамтарч ойн цэвэрлэгээг хийх замаар унианг мод, хожуул, гишүү зэрэг хаягдал модыг иргэдийн түлшний хэрэгцээнд авч ашиглах ажлыг зохион байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН БОДЛОГО

3.1. ЗАСАГЛАЛ

- 3.1.1. Орон нутагт дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Төрийн албаны томилгоонд улс төрийн албан хаагчийн нөлөөллийг хязгаарлана.
- 3.1.3. Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого, шийдвэр, үүрэг даалгаварын биелэлтийг цахимаар хянадаг болно.
- 3.1.4. “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөрийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулна.
- 3.1.5. Төрийн албан хаагчдын хувийн болон хамтын манлайллыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- 3.1.6. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, шийдвэрийн хэрэгжилтийг шилэн болгож, иргэдийн оролцоог хангах механизм бий болгож сайн туршлага бий болгоно.
- 3.1.7. Бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
- 3.1.8. Багуудын уялдаа холбоог сайжруулж, хамтарч ажиллах, хөгжих шинэ санал санаачлалыг дэмжиж ажиллана.
- 3.1.9. Хөрш орнуудын муж, хотуудтай тогтоосон түншлэл, хамтын ажиллагаагаа шинэ агуулгаар баяжуулан хөгжүүлж, хөгжлийн олон тулгуурт бодлого хэрэгжүүлэх шаардлагын үүднээс олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 3.1.10. Зэргэлдээх аймаг, сумдуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдвэрлэнэ.
- 3.1.11. Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, төрийн албаны үйл ажиллагаанд үндэсний хэмжээнд шинээр хэрэгжүүлж байгаа гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх системийн хүрээнд бодлого боловсруулж ажиллана.
- 3.1.12. Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэд оршин суугчдын ая тухтай байдлыг бүрдүүлнэ.
- 3.1.13. Гэмт хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн үндсэн дээр бүх төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, техник тоног төхөөрөмжийн хангамж, үйл ажиллагааны чанарыг сайжруулж ажиллана.
- 3.1.14. Нийгмийн түншлэлийн хүрээнд талуудын оролцоог нэмэгдүүлж, хяналтын тогтолцоог сайжруулна.

- 3.1.15. Нутгийн удирдлагын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн ялгааг оновчтой тодорхойлж ажиллана.
- 3.1.16. Сумын хэмжээнд “Нутгийн удирдлагын засаглалыг сайжруулах хөтөлбөр” хэрэгжүүлнэ.
- 3.1.17. Нутгийн удирдлагын байгууллагын дотоод үйл ажиллагааны бодлогын шинэчлэл, Чанарын нэгдсэн удирдлага, үндэсний стандартыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудыг нэмэгдүүлнэ.
- 3.1.18. Орон нутгийн ЗДТГ-ыг үндэсний хэмжээний “Жишиг нутгийн захиргааны байгууллага” болгоно.
- 3.1.19. Нутгийн удирдлагын байгууллагын ил тод байдал, дотоод, гадаад хамтын ажиллагаа, зохицуулалт, хариуцлагын тогтолцоог сайжруулна.
- 3.1.20. Сумын хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавх, хариуцлагын тогтолцоог сайжруулна.
- 3.1.21. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн орчинг төрийн бүх байгууллагад төлөвшүүлнэ.
- 3.1.22. Сумын хэмжээний үйл ажиллагаанд хяналт тавьж, авлига, шударга бус үйлдлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг бий болгоно.
- 3.1.23. Аюулгүй байдлын эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг иж бүрэн нэвтрүүлж, иргэдийн аюулгүй орчинг бүрдүүлнэ.
- 3.1.24. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 3.1.25. Зайлшгүй шаардлагатай асуудлаар “Нээлттэй сонсгол”-ыг зохион байгуулж, иргэдийн мэдэх эрх, оролцоог хангана.

3.2. ЦАХИМ ХӨГЖИЛ

- 3.2.1. Төрийн үйлчилгээний цахим платформыг хөгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлж E-mongolia системийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилан таниулж, төрийн үйлчилгээг хялбаршуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ.
- 3.2.2. Төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, цахим хөтөчийг шинээр бий болгоно.
- 3.2.3. Цахим хотын стандартыг бий болгож мөрдөнө.
- 3.2.4. Төрийн үйлчилгээнд дахин инженерчлэл хийж шат дамжлагыг оновчтой болгож, үйлчилгээг хялбаршуулах ажлыг зохион байгуулна.
- 3.2.5. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдсэн мэдээллийг цахимд байршуулах ажлыг зохион байгуулж, иргэдийг хотын талаарх мэдээллээр түргэн шуурхай хангах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**